ШУУРХАЙ ХЯНАЛТЫН ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ЦОГТСАЙХАН ОВОГТОЙ ХАТАНБОЛДЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрсэн түвшин /Эхний хагас жил/ | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 2. “Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах”** | | | | | | | |
| 1. | Теле хяналтын нэгдсэн систем, камерын хэвийн, найдвартай, аюулгүй байдлыг ханган ажилласан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 50% | ***ТХНС, дагалдах тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллааг хангах чиглэлээр:***<br>Тайлант хугацаанд төвийн дарга Ц. Хатанболд миний бие болон ГУАБ Д. Ганцолмон, Б.Дөлгөөн, Н.Дөлгөөн нар ЗҮГГ, ЧХОУНБ, УБГГ, БиГГ, ШХГГ, ГСГГ, СЭГГ, Баянхошуу, Хавирга боомтуудад ашиглаж буй телехяналтын дэд систем, ухаалаг гарц, рентген тоног төхөөрөмжийн холболт тохиргоо хийх, тэдгээрийн хэвийн ажиллагааг хангуулах зорилгоор 9 удаагийн томилолтоор ажилласан.<br>УБГГ-ын хяналтад Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахаар хүсэлт илгээсэн "МЛ Урбан" ХХК-ийн хүсэлтэд холбогдох журмын хэрэгжилтийг хангуулах санал өгч, тухайн ААН-ийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл нь хууль тогтоомжийн хүрээнд баталгаажсан. Тус хугацаанд ХБГ, ШХТ, УБГГ болон УХШИГГ-ын албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр 2 удаагийн уулзалт зохион байгуулж, зайлшгүй нэмэлтээр камер суурилуулах шаардлагатай 12 цэгийг тодорхойлж, нийт 25 ш камерыг ТХНС-д холбосон.<br>Харьяа гаалийн газар, хороод, гаалийн хяналтын бүсүүдэд ашиглагдаж буй дэд систем, хяналтын камер бусад тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, эвдрэл гэмтэл, саатал гарсан тохиолдолд хариу арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээн Гаалийн ерөнхий газрын даргын удирдамжаар Сэлэнгэ аймаг дахь гаалийн газарт ХБГ-ын ГУБ М.Батбилэг, ШХТ-ийн ГУБ Н.Дөлгөөн нар 2025 оны 01 | 2025.01.02-2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүгээр сарын 27-ний өдрөөс 30-ны өдрийн хороонд тус гаалийн газарт ажиллан дараах ажлыг гүйцэтгэсэн. Үүнд: Алтанбулаг боомтын экспорт болон импорт талд нэмэлтээр 2ш телехяналтын камер суурилуулах цэгүүдийг тодорхойлсон. Мөн бүтээн байгуулалттай холбоотойгоор түр ашиглагдаж буй импортын хяналт хийгдэж байгаа талбайд 2ш телехяналтын камерыг суурилуулан, тохиргоог хийж, телехяналтын нэгдсэн системд холбосон. Алтанбулагийн чөлөөт бүсийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүд болон Чөлөөт бүсийн захиргааны төлөөлөлтэй уулзалт хийж, гаалийн телехяналтын нэгдсэн системд холбох ажлыг эрчимжүүлэх чиглэл зааварчилгааг өгсөн.<br><br>Шуурхай хяналтын төвийн тог баригчийг сольж, телехяналтын системийн хэвийн ажиллагааг хангаж ажилласан.<br><br>ЧХОУНБ дахь гаалийн газарт ажиллан, тус хяналтын бүсийн явагчийн биеэс тусдаа ачааны 2ш, ирэгчийн гар тээшний 2ш рентген төхөөрөмжүүдийг телехяналтын нэгдсэн системд холбох тохиргоог хийн, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих нөхцөл боломжоор хангалаа. Төлөвлөгөөгөөр явагчийн гар тээшний 2ш рентген төхөөрөмжийг холбох байсан боловч холболт хийхэд нэмэлтээр хөрвүүлэгч болон бусад кабель утасны шаардлага гарч, зардлыг шийдвэрлүүлэх шаардлага гарсан тул холболтын ажлыг түр хойшлуулсан.<br><br>УХШИГГ-ын харьяа Буянт-Ухаа дахь Ди Эйч Эл салбарын гаалийн хяналтын бүсэд байрших захидал илгээмжийн рентген-1ш, Монгол шуудангийн гаалийн хяналтын бүсэд байрших илгээмжийн рентген-1ш төхөөрөмжүүдийг телехяналтын нэгдсэн системд холбосон. Цаашид эдгээр хоёр ААН-д сүлжээний хурдыг сайжруулах шаардлагыг албан бичгээр хүргүүлэхээр төлөвлөсөн.<br><br>Алтанбулаг боомтын гарах чиглэлд суурилуулагдсан том оврын тээврийн хэрэгслийн рентген-1, зорчигчийн экспорт болон импортын гар тээшний рентген-2 төхөөрөмжийг телехяналтын нэгдсэн системд холбож, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлсэн.<br><br>Гаалийн газар хороодод суурилуулсан том оврын тээврийн хэрэгслийн рентген /ИСБА/ тоног төхөөрөмжүүдийн зургийг нэгтгэн боловсруулалт хийх туршилтын ажлыг эхлүүлсэн.<br><br>УХШИГГ-ын харьяа Буянт-Ухаа дахь Ди Эйч Эл салбарын гаалийн хяналтын бүсэд байрших захидал илгээмжийн рентген-1ш, Монгол шуудангийн гаалийн хяналтын бүсэд байрших илгээмжийн рентген-1ш төхөөрөмжүүдийг телехяналтын нэгдсэн системд холбосон. Цаашид эдгээр хоёр ААН-д сүлжээний хурдыг сайжруулах шаардлагыг албан бичгээр хүргүүлэхээр төлөвлөсөн.<br><br>Алтанбулаг боомтын гарах чиглэлд суурилуулагдсан том оврын тээврийн хэрэгслийн рентген-1, зорчигчийн экспорт болон импортын гар тээшний рентген-2 төхөөрөмжийг телехяналтын нэгдсэн системд холбож, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлсэн.<br><br>Гаалийн газар хороодод суурилуулсан том оврын тээврийн хэрэгслийн рентген /ИСБА/ тоног төхөөрөмжүүдийн зургийг нэгтгэн боловсруулалт хийх туршилтын ажлыг эхлүүлсэн.<br><br>Харьяа гаалийн газар хороодод хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа болон эвдрэл гэмтэлтэй байгаа бүх рентген тоног төхөөрөмжийг бүртгэлжүүлсэн. Цаашид телехяналтын нэгдсэн системд холбогдоогүй байгаа рентген төхөөрөмжүүдийг холбох ажлын хүрээнд ГСГГ-ын зорчигчийн гар тээшний 2 ширхэг рентгэн төхөөрөмж, СЭГГ-ын Алтанбулаг боомтод ашиглагдаж буй гар тээшний 2ш, Ачаа тээврийн 1ш рентген тоног төхөөрөмжүүдийг, ЧХОУНБГГ-ын явагчийн биеэс тусдаа ачааны 2ш, гар тээшний 2ш, ирэгчийн гар тээшний 2ш төхөөрөмжүүдийг, мөн УХШИГГ-ын харьяа Буянт-Ухаа дахь Ди Эйч Эл ГХБ-д байршил захидал илгээмжийн рентген 1ш төхөөрөмжийг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | телехяналтын нэгдсэн системд холбож өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих боломжтой болсон<br><br>ГЕГ-ын ШХТ-өөс ЗҮГГ-т 2025 оны 02-р сарын 21-ны өдрийн 01-2.2/837 дугаартай албан бичгээр Гаалийн хяналтын бүсүүдийн нийт 60 камер ажилахгүй байгааг засварлах шаардлага хүргүүлсэн. Уг ажлын хүрээнд арга хэмжээ авч хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл 50%тай байна.<br><br>ГСГГ-ын харьяа Оюутолгой гаалийн хяналтын бүсэд суурилуулсан Ухаалаг гарцын тоног төхөөрөмжүүдийг Гаалийн байгууллагын smartgate болон CAIS системтэй холбон, үүнээс экспортын гарах, импортын орох, гарах чиглэлд суурилуулсан 3 гарцыг тестийн орчинд туршиж, нэвтрүүлсэн.<br><br>Ухаалаг гарцын систем дээр эрсдэлийн тооцоолол оруулах бодлогын даалгавар боловсруулах ажлын хүрээнд авто замын хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгсэлд эрсдэл тооцох шалгуурын саналыг боловсруулан МТГ-т хүргүүлсэн. Одоогоор эрсдэлийн шалгуурыг тестийн орчинд шалгах туршилтын ажил хөгжүүлэлтийн үе шатанд явж байна.<br><br>ГТЛ-ийн 2025 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн №01720/42 дугаартай дотоод зурвасын дагуу ГТЛ-ийн барилгын хойд буланд суурилуулсан гадна хаалга руу харсан камерыг шинээр сольж хэвийн ажиллагаанд оруулсан.<br><br>БӨГГ-н чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулдаг 3 дэлгүүрийн телехяналтын системүүдийг шалгаж хэвийн ажиллагааг хангаж ажилласан.<br><br>Замын-Үүд гаалийн газрын хэрэгцээнд худалдан авах шаардлагатай байгаа дугаар таних камерын 20 ширхэг тэжээлийн үүсгүүр /Poe Injector/-ийн техникийн үзүүлэлтийг боловсруулж 2025.04.16-ны 01/51 дугаар дотоод зурвасаар хүргүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | - Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг телехяналтын нэгдсэн системд холбох ажлын хүрээнд камерын угсралт суурилуулалт хийхээр сонгогдсон аж ахуйн нэгжээс ирүүлсэн тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийг хянаж үзээд телехяналтын серверийн RAM хангалтгүй, серверт байрлах 40 камерын бичлэгийг 12 сарын хугацаатай хадгалах боломжтой болгож, багтаамжыг нэмэх, цахилгаан тасарсан үед серверүүдийг тэжээх 1 тог баригч төлөвлөсөн боловч камер тэжээх тог баригч төлөвлөөгүй тул шийдлийг дахин боловсруулах, телехяналтын камеруудын байршил, тоо хэмжээний талаарх саналыг Сэлэнгэ аймаг дахь гаалийн газартай хамтран төлөвлөж ажиллах тухай 2025.04.25-ны өдөр 01-2.2/1739 тоот албан бичиг хүргүүлсэн.<br><br>- ЧХОУНБГГ-ын олон улсын ирэх чиглэлийн зорчигчийн ачаа тээш шалгах 3 ширхэг рентген аппаратууд, ирэх чиглэлийн зорчигчийн биеэс тусдаа ачаа тээш шалгах аппаратын хэвийн ажиллагаанд хяналт тавьж, генератор солих санхүүжилтийн асуудлыг чиг үүргийн нэгжээр шийдвэрлүүсэн.<br><br>- "Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авах тухай мөрдөгчийн 22 дугаартай мэдэгдлийн хүрээнд гаалийн хяналтын бүсүүдийн телекамерын өнөөгийн нөхцөл байдлын судалгааг гаргаж телекамер болон сервер тоног төхөөрөмжид тавигдах холбогдох журмуудад заасан шаардлагыг хангуулах ажлыг зохион байгуулж гарсан үр дүнг эргэн мэдэгдэх" хугацаатай үүрэг даалгаврыг ГСГГ-т 2025 оны 4 сарын 15-ны өдрийн 01-2.2/1524 дугаар дотоод зурвасаар хүргүүлж, мэргэжлийн зөвлөмж чиглэлээр ханган ажилласны дагуу туршилт шалгалт хийж, 47 гаалийн хяналтын бүсүүдэд ашиглагдаж байгаа 1477 теле хяналтын камераас 1438 телехяналтын камер нь хэвийн ажиллаж, 39 телехяналтын камер тодорхой | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шалтгааны улмаас ажиллахгүй байгааг тогтоож, хяналтын бүс эрхлэгч нарт шаардлага хүргүүлсэн.<br><br>***Телехяналтын камер, дагалдах тоног төхөөрөмжийн судалгааны чиглэлээр:***<br>- 2025 онд нэмэлтээр суурилуулах телехяналтын камер, бусад дагалдах тоног төхөөрөмжийг худалдан авах ажилтай холбогдуулан ГЕГ-ын мэргэжлийн зөвлөлд бараа, материалын судалгааг танилцуулан тус хурлаас өгсөн зөвлөмжийн хүрээнд харьяа гаалийн газар, хороодод хуваарилах санал болон худалдан авах бараа, материалын техникийн тодорхойлолтыг боловсруулан СХОГ-т хүргүүлсэн.<br><br>/ЧХОУНБГГ-т 58 камер, Буянт-Ухаа ГХБ-д 5 камер суурилуулахаар төлөвлөсөн/<br><br>- Харьяа гаалийн газар хороодод хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа болон эвдрэл гэмтэлтэй байгаа бүх рентген төхөөрөмжийн судалгааг хийсэн (судалгааг хавсаргав). Судалгааны дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглагдаж буй, гаалийн байгууллагын телехяналтын нэгдсэн системд холбох боломжтой рентген төхөөрөмжүүдийг хөрвүүлэгч болон бусад холбох төхөөрөмжийн нөөц боломжид тулгуурлан холболтуудыг хийсэн.<br><br>- Хяналтын дэд төвд суурилуулсан тоног төхөөрөмж, дэлгэцийг анхны төлөвлөсөн тоо ширхгээр зориулалтын дагуу ашиглаж, гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаа, хяналтын бүсийн дэглэм сахиулах болон албан хаагчдын аюулгүй байдалд өдөр тутамд хяналт тавин ажиллах талаар БӨГГ-т 01-2.2/2056 дугаар албан бичиг хүргүүлэв. | | |
| 2. | Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн чиглэлээр ашиглагдах бүх төрлийн мэдээллийг төрөлжүүлэн | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 50% | Шуурхай хяналтын төвийн зөвлөмжийн шалгуурын дагуу Tableau програмд сонгогдсон мэдүүлгүүд, ЗҮГГ-ын бүрдүүлэлтийн мэдээ, зөрчлийн мэдээ /2024 он/-д дүн шинжилгээ хийж /нийт сонгогдсон мэдүүлгийг ААН-ээр жагсаан, 10-аас дээш удаагийн давтамжтай ААН-үүдийг | 2025.01.02-2025.06.10 | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цуглуулж, сан үүсгэх, дүн шинжилгээ хийсэн байдал | | | | сонгон авч/ мэдээллийг боловсруулан гаргаж, дэд даргад PPT материал танилцуулахаар бэлдсэн.<br>- Татвар, орлогын газрын 2025 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн №01110/55 дугаар албан бичгийн дагуу, Гаалийн ерөнхий газрын даргын баталсан "Гаалийн байгууллагын 2025 оны Монгол Улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах ажлын төлөвлөгөө"-ний хүрээнд дэд даргын баталсан төлөвлөгөөний Том оврын ачаатай автомашиныг рентгенээр оруулаагүй, овор хэмжээг хэтрүүлэн ачдаг тээврийн хэрэгслийн судалгаа, давтамж буюу барааны үнийн дүн, жин тн-ыг нэгтгэн дүн шинжилгээ хийхээр ажиллаж байна.<br>- Улсын хилээр импортолсон олон нэр төрлөөр мэдүүлж байгаа мэдүүлэгт дүн шинжилгээ хийх зорилгоор Таблью дата платформ ашиглан дашбоард хийхээр МТГ-тай хамтран КАИС автоматжуулсан системийн дата баазаас гаалийн мэдүүлэг болон тээврийн хэрэгслийн сүүлийн 5 жилийн мэдээллийг татаж, боловсруулсан. Энэхүү дашбоардыг нэвтрүүлснээр цаашид тогтмол хяналт тавих нөхцөл бололцоо бүрдэнэ. Энэ зорилтот ажил 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12-р сарын төлөвлөгөөнд үргэлжлэн тусгагдаж бүрэн биелэнэ. | | |
| 3. | Мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан онилгоо хийн, зөвлөмж илгээсэн байдал | Хэрэгжилт, хувиар | 100% | 50% | CAIS-д мэдүүлсэн бараа тээврийн хэрэгслийн өгөгдлийг Таблью дата аналитик платформ ашиглан, бодит цагаар боловсруулан сонгогдсон эрсдэлтэй гаалийн мэдүүлэгт Телехяналтын нэгдсэн систем болон рентген тоног төхөөрөмж, ухаалаг гарц, дугаар таних системд хүлээн авсан мэдээлэлд давхар дүн шинжилгээ хийн, эрсдэл тооцож, CAIS Зөвлөмжийн програмаар тайлант хугацаанд 62 зөвлөмжийг гаалийн хяналт шалгалт, бүрдүүлэлтийн бүх үе шатанд илгээсэн байна. Үүнээс 59 буюу **95.16%**-д нь татвараас зайлсхийсэн болон зайлсхийхийг завдсан, эрх бүхий байгууллагын тусгай зөвшөөрлөөр улсын хил нэвтрүүлэх шаардлагатай хориглосон хязгаарласан барааг хууль бусаар хил нэвтрүүлэхийг завдсан зөрчлүүдийг илрүүлсэн байна. | 2025.01.02-2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Зөвлөмжийн дагуу илрүүлсэн 59 зөрчилд Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 11.21 дүгээр зүйлийн 1.1, 1.2 заалтын дагуу арга хэмжээ авагдаж, **369.93 сая.төг** татварыг нөхөн төлүүлж, **150.08 сая.төг** торгууль ногдуулан төлүүлсэн.<br><br>- 1 удаагийн үйлдлээр 3 тээврийн хэрэгсэл "хар цаас" гэж мэдүүлсэн 89.75 тн хориглосон хязгаарласан барааг /хөрстэй мод/ улсын хилээр хууль бусаар, худал мэдүүлж нэвтрүүлсэнийг илрүүлж таслан зогсоолоо.<br><br>- 1 удаагийн үйлдлээр 2 тээврийн хэрэгсэл "цемент" гэж мэдүүлсэн 83,37 тн бараа нь зөвлөмж илгээснээр хяналт шалгалтаар /полистирол 48370 кг, полиэтилен 35000 кг/ улсын хилээр худал мэдүүлж нэвтрүүлснийг илрүүлж, эрүүгийн хуулийн 18.3-р зүйл харьяаллын дагуу Замын-Үүд сумын сум дундын цагдаагийн хэлтэст шилжүүлж, 76.0 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлсэн. | | |
| 4. | Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн бүх үе шатанд тавьсан хяналт, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлсэн байдал, аюулгүй байдлыг хангахад хамтран ажилласан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 50% | Таблью дата аналитик платформ ашиглан, бодит цагаар боловсруулан сонгогдсон эрсдэлтэй гаалийн мэдүүлэгт Телехяналтын нэгдсэн систем болон рентген тоног төхөөрөмж, ухаалаг гарц, дугаар таних системд хүлээн авсан мэдээлэлд давхар дүн шинжилгээ хийн, эрсдэл тооцож CAIS-ийн онилгооны програмаар тайлант хугацаанд 62 зөвлөмжийг гаалийн хяналт шалгалт, бүрдүүлэлтийн бүх үе шатанд илгээснээс 59 буюу 95,16%-д нь татвараас зайлсхийсэн болон зайлсхийхийг завдсан зөрчлүүдийг илрүүлж, таслан зогсоосон байна. | 2025.01.02-2025.06.10 | 100% |
| 5. | Гаалийн байгууллагатай холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 70% | 50% | 2025 оны 01 дүгээр 02-оос 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар Гаалийн лавлах 1800-1281 тусгай дугаарт гомдол-93, зөрчлийн мэдээлэл-14, санал-6, хүсэлт-4, шүүмжлэл-3, асуулт лавлагаа-5628 буюу нийт 5735 дуудлага, ЗГ Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан гаалийн байгууллагатай холбоотой гомдол- | 2025.01.02-2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 101, санал-5, хүсэлт-9, шүүмжлэл-1, талархал-1 буюу нийт 117 дуудлага тус тус бүртгэгдсэн байна.<br><br>Гаалийн байгууллагад ирсэн гомдол, санал, хүсэлт, зөрчлийн мэдээллийн шийдвэрлэлтийн явцын 7 хоног бүрийн мэдээг Цахим болон шуурхай хуралд, ГЕГ-ын дарга болон ЗТГ-ын даргад тайлагнаж, удирдлагыг мэдээ мэдээллээр хангаж ажилласан.<br><br>Иргэн, аж ахуйн нэгжид гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх, гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн тайланг улирал бүр ОНХА-д, Гаалийн лавлах 1800-1281-ээр хүлээн авсан дуудлага, гомдол мэдээллийн сар бүрийн тайланг СДШХ-т тус тус хүргүүлэн ажилласан. | | |
| 6 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 96% | 50% | - Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн сар бүрийн болон 2025 оны 1 дүгээр улирлын тайланг Хуулийн хэлтсээр дамжуулан Сангийн яаманд хүргүүлсэн.<br>- ГЕГ-ын даргын баталсан Гаалийн байгууллагын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу Гаалийн байгууллагатай харилцаанд оролцогчдод Гаалийн лавлах 1800-1281 болон Авилгатай тэмцэх газрын 110 тусгай дугаарыг сурталчлан таниулах зорилгоор тусгай дугаараас харьяа гаалийн газар, хороод руу шилжсэн салбар дуудлага бүрийг бүртгэх, мөн уг тусгай дугаарыг гаалийн харилцаанд оролцогчдод сурталчлан таниулах зорилгоор постерын эх хувийг боловсруулж, ЗУГ-аар батлуулан, ГХБ, БА, ЧБүсүүдын мэдээллийн самбар хэсэгт байршуулахаар 2025 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн №01-1/1352 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Тус ажлын явцын тайланг 2025 оны 4 дүгээр сарын 11-ний дотор ШХГГ, УвГГ, ЗҮГГ, УБГГ, ОрГГ, БӨГГ, ХоГГ, БуГХ, ДАГГ, ЗаГХ, СШГГ, ДоГГ, БИГГ, ХаГГ, УХШИГГ, ГСГГ, СЭГГ, ЧХОУНБГГ гаалийн газар, хороод тус тус ирүүлсэн.<br>- “Гаалийн байгууллагын 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 2.4-т заасан | 2025.01.02-2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал, чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших" ажлын хүрээнд хийсэн ажлын тайланг холбогдох судалгааны хамт хавсралтаар /1 дүгээр хавсралт: ШХТ 2025 оны 1-р улирлын судалгаа, шийдвэрлэлт, 3 хуудастай. 2 дугаар хавсралт: ШХТ-ын 2025 оны 1 дүгээр улирлын тайлан, дүгнэлт, 2 хуудастай/ ЗУГ-т 2025.05.21-ны өдөр 01/75 дугаар дотоод зурвасаар хүргүүлэв.<br><br>- 2025.06.06-ны 01/81 дугаар дотоод зурвасаар ЗУГ-т доорх ажлыг хүргүүлсэн. Улсын хөгжлийн 2025 төлөвлөгөөний Гаалийн мэдээллийн автоматжуулсан систем болон телехяналтын нэгдсэн системийн их өгөгдөлд дүн шинжилгээ хийх хиймэл оюун ухаанд суурилсан онилгооны системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд: 2024 онд Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг (KOICA)-ын төслийн дэд дарга И Кан Сон удирдсан төслийн багийн гишүүдтэй уулзалт зохион байгуулагдсан. Уулзалтын үеэр дараах чиглэлээр тодорхой санал, санаачлагууд дэвшүүлж, ажлын даалгаврыг боловсруулсан.<br>Энэхүү ажлын хүрээнд:<br><br>"Гаалийн лавлах 1800-1281"-ийн OneCall үйлчилгээний шинэчлэл:<br><br>-Их өгөгдөл болон хиймэл оюун ухаанд суурилсан технологиор шинэчлэн боловсруулж, хэрэглэгчдэд автомат хариу өгөх боломжтой AI дуудлагын системийг нэвтрүүлнэ.<br><br>AI-д суурилсан онилгооны систем хөгжүүлэлт:<br><br>-Гаалийн хяналт, шалгалтын үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор эрсдэлийг автоматаар тодорхойлох алгоритмыг боловсруулж, програмд "онилох систем"-ийг нэвтрүүлнэ | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төслийн баримт бичигт 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Монгол Улсын Сангийн сайд болон KOICA-ийн Ерөнхийлөгч нар гарын үсэг зурахаар төлөвлөсөн.<br><br>Төсөл нь 2025 оны 9 дүгээр сараас албан ёсоор эхэлж, 2028 онд бүрэн хэрэгжиж дуусах юм. | | |
| 7 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 50% | Нэгжийн чиг үүрэгт хамаарах захиргааны хэм хэмжээний актад санал хүргүүлсэн. Үүнд:<br>- Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам шинэчлэн батлагдах гэж буйтай холбогдуулан ГЕГ-ын даргын 2012 оны А/83 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн хяналтын бүс болон баталгаат бүсэд ашиглах мэдээллийн систем, технологид тавигдах шаардлага, тоног төхөөрөмжийн үзүүлэлт”-ийн төслийг шинэчлэн боловсруулж, тус журамтай зэрэгцүүлэн /ААН-д жигд шаардлага тавих зорилгоор/ батлуулах саналаа ХБГ-т дотоод зурвасаар хүргүүлсэн.<br><br>- Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/190 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал”-ын 1.20 дугаар хавсралтад тусгасан шалгуурт оруулах саналыг дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>- Нэгжийн 2025 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан, ЗУГ-т дотоод зурвасаар хүргүүлсэн.<br><br>- ЗДАСистемийн “Дуудлагын төв” цэсэнд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Мэдээллийн технологийн газарт дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>- ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-ыг шинэчлэн боловсруулах төсөлд эрх бүхий байгууллагаас өгсөн зөвлөмжийн хүрээнд саналыг боловсруулж, ХБГ-т дотоод зурвасаар хүргүүлсэн.<br><br>- Засгийн газрын тогтоол шийдвэрийн 2025 оны 01 дүгээр улирлын биелэлтийг гарган, ХХ-т дотоод зурвасаар хүргүүлсэн. | 2025.01.02-2025.06.10 | |
| 8. | Нэгжийн эрсдэлийн | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 80% | 50% | - Эрсдэлд суурилсан гаалийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх зорилгоор Ухаалаг гарцын системд тээврийн хэрэгслийн эрсдэлийн шалгуур оруулахаар | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | | | | төлөвлөсний дагуу КАЙС системд "Зөрчилд холбогдсон тээврийн хэрэгслийн сан"-г нэмэлтээр оруулах саналыг МТГ-т дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>- Нэгжийн 1 албан хаагч Эрсдэлийн удирдлагаас 2025.04.23-ны өдөр зохион байгуулсан эрсдэлийн удирдлагын худалдааг хөнгөвчлөх сургалтанд хамрагдан 36 арга хэмжээ тус бүрээр /UN trade & development/ программд орж ажиллаж байна. | | |
| 9. | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 90% | 50% | ЗДАС-ын Үүрэг даалгаврын цэсэд Захиргааны удирдлагын газраас ирүүлсэн 3 үүрэг даалгаварын биелэлт, Татвар орлогын газраас ирүүлсэн 1 үүрэг даалгаварын биелэлт, Сургалтын төвөөс ирүүлсэн 1 үүрэг даалгаварын биелэлт, Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газраас ирүүлсэн 12 үүрэг даалгаварын биелэлтийг хангаж, тайланг /нийт 17/ оруулж дүгнүүлсэн.<br><br>ГЕГ-ын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрт нь хийж хэрэгжилтийг хангаж, биелэлтийг танилцуулан ажилласан. | 2025.01.02-2025.06.10 | 100% |
| 10. | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 80% | 50% | Тайлант хугацаанд Хөдөлмөрийн дотоод журмын дагуу төвийн бүх албан хаагч ажлын өдрийн өглөө, орой бүр цаг бүртгэлийн царай таних төхөөрөмжид тогтмол бүртгүүлж, зайлшгүй шаардлагаар гадуур ажиллах, томилолтоор явах, өвчтэй, чөлөөтэй тохиолдолд CERP-д тухай бүр хүсэлтээ оруулан илгээж ажилласан.<br><br>Албан хаагчдын ажлын цаг ашиглалтын байдалд тогтмол хяналт тавьж ажилласан ба ГУБ болон ГУАБ нарын ажлын үзүүлэлтэд цаг ашиглалтыг дүгнэж, ТЖАХ-ын ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд тусгаж дүгнэсэн. | 2025.01.02-2025.06.10 | 100% |
| 11. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 60% | 50% | ***Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, ажлын хэсгийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:***<br><br>- 2025 оны ГЕГ-ын албан хаагч нарын ажлын үнэмлэхний бүртгэлийг систем дээр бүрэн цэгцэлж, бүртгэлгүй түр картуудын эрхийг хааж, хүчингүй болгосон. | 2025.01.02-2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.1-д заасны дагуу төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор “shilen.gov.mn” цахим хуудсанд байршуулахаар 2025 оны 01 дүгээр улиралд Гаалийн байгууллагад хүлээн авч шийдвэрлэсэн гомдол мэдээллийн тайлан мэдээг ОНХА-д хүргүүлсэн.<br><br>- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд ЗГ 11-11 төв, Гаалийн лавлах 1800-1281 тусгай дугаар, Бүрдүүлэлтийн цахим төвд цахимаар ирсэн нийт гомдол, санал, хүсэлтийн 2025 оны 1 дүгээр улирлын тайланг ЗУГ-т хүргүүлсэн.<br><br>- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хүрээнд албан хаагчдын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв"-өөр хийлгүүлэхээр төлөвлөсний дагуу тус төвтэй хамтран ажиллах гэрээний төслийг бэлдэж, хуулийн хэлтсээр хянуулж дууссан бөгөөд үнэлгээний төлбөр болох 1,161,000 /Нэг сая нэг зуун жаран нэг мянган төгрөг/-ийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж өгөх талаар СХОГ-т 01/73 дугаар дотоод зурвасаар хүргүүлсэн.<br><br>- Нэгжийн албан хаагчид тайлант хугацаанд 4 ажлын хэсэгт, 6 цаг үеийн шинжтэй арга хэмжээнд, ЗУГГ, ЧХОУНБ, УБГГ, БиГГ, ШХГГ, ГСГГ, СЭГГ, Хавирга, Баянхошуу боомтуудад ашиглаж буй телехяналтын дэд систем, ухаалаг гарц, рентген тоног төхөөрөмжийн холболт тохиргоо хийх, тэдгээрийн хэвийн ажиллагааг хангуулах зорилгоор 9 удаагийн томилолтоор ажиллан, тэдгээрийн хэрэгжилтийг хангаж ажиллаж, асуудлуудыг шийдвэрлэн оролцсон. | | |

## ...мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Төрийн албаны тухай хуулийн дагуу богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - Сангийн яамнаас зохион байгуулсан Жендэрийн стратегийн үнэлгээний талаарх техникийн зөвшилцөх сургалт-семинарт оролцсон.<br>- Сургалтын төвөөс зохион байгуулсан VR 4 цагийн сургалтад 2024 оны 01-р сард хамрагдсан.<br>- Anti-Money laundering investigation techniques workshop-д хамрагдсан.<br>- Төрийн албаны удирдах албан тушаалтны ур чадварыг хөгжүүлэх нь сэдэвт сургалтад хамрагдаж, сертификат авсан.<br>- Төрийн худалдан авах ажиллагааны А3 мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, сертификаттай төгссөн. | Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна. | - Гаалийн байгууллага, "Арш Технологи" ХХК-тай хамтран зохион байгуулсан Шуурхай хяналтын төвийн телехяналтын нэгдсэн систем, харьяа гаалийн газар, хороодын 29 дэд телехяналтын системд ажиллах албан хаагчдын Genetec системийн орчинд ажиллах ур чадварыг сайжруулах, тухайн системээс олж авсан бичлэг, мэдээлэл, өгөгдлийг бүрэн ашиглах чадавхыг нэмэгдүүлэх сургалт<br>- Улсын ерөнхий прокурорын газраас "Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны програмын ашиглалт" сургалт<br>- Нийслэлийн прокурорын газараас зохион байгуулсан "Зөрчил шалган шийдвэрлэх арга зам" сургалт<br>- ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газар, ТЕГ-ын Нийслэлийн тагнуулын газар, ГЕГ-ын ЗТГ-ын хамтран зохион байгуулсан "Улс хоорондын шуудан илгээмжийн өнөөгийн нөхцөл байдал, эрсдэл" сэдэвт сургалт<br>- Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Захиргааны удирдлагын газар хамтран зохион байгуулсан Нэгжийн үйл ажиллагааны тайлагналт, анхаарах асуудлын талаарх сургалтуудад тус тус хамрагдсан | 2025.01.01-2025.06.10 | 100 |
| 2. | Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Англи хэл бие даан сурч, зохих түвшний мэдлэгтэй болсон. | Бие дааж унших судалсан байна. | Бие даан англи хэлний мэдлэгээ онлайнаар "Wall street english" сургалтын төвд В2 шатны сургалт ашиглан дээшлүүлсэн. | 2025.01.01-2025.06.10 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ШУУРХАЙ ХЯНАЛТЫН ТӨВИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ............................... / Ц. Хатанболд / 2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

## ШУУРХАЙ ХЯНАЛТЫН ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ХАТАНБОЛДЫН 2025 ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Шуурхай хяналтын төв

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт оноо (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | | 56,1 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийг хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | | 14 |
| 2. | Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх | | 14 |
| **Мэдлэг. ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо:** | | | 14 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 12 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 11 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 12 |
| 4. | Манлайлах | 12 |
| 5. | Багаар ажиллах | 11 |
| 6. | Харилцаа | 11 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 11 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|

| | | |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | 56,1 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 14 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 11 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт | — |
| **Нийт оноо=** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 81,1 |

**Үнэлгээ өгсөн:** **Төсвийн шууд захирагч:**

Гаалийн ерөнхий газрын дарга ........................ (Р.Отгонжаргал)

2025.06.25 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:** **Нэгжийн дарга:**

Шуурхай хяналтын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ........................ (Ц.Хатанболд)

2025.6.10. (огноо)